

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2020/15/СТА/ТТЗ**

---

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2020 он

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716

Аудитор: П.Содном

Утас: 70342495

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	10
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.13. Шилэн дансны мэдээлэл .....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал .....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	22
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	23
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан..	<b>Error! Bookmark not defined.</b>

## Аудитын гэрчилгээ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Г БАЯННУУР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.ЁНДОН ТАНАА Г

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020-03-08 № 139

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяннуур сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баяннуур сумын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын

стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ДАНХБАЯР



## Аудитын тайлан

### **2.1. Оршил**

Баяннуур сумын Засаг даргын нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Б.Ёндонд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 16-аас 2020 оны 03 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04 –ний өдрийн 01/42 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баяннуур сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баяннуур сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Оновчтой бодлого зохицуулалтаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлж, иргэддээ орон нутагтаа ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Төрийн үйлчилгээг өдөр тутам иргэдэд шуурхай хүргэж,*
- *Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт хийж мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх,*
- *Дээд шатны бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх*

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны

Төсвийн тухай хуулийн тухай хууль, тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Албан байгууллагын нягтлан бодогч нар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд CTS программ хангамж ашигладаг, нэгтгэсэн тайланг Э-тайланд нэгтгэдэг байна.

Баяннуур сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд их гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 4 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардал 2276213225.96 төгрөг бөгөөд 2 хувь 45524264.52 мянган төгрөгөөр тооцлоо.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баяннуур сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239848.7 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	24848.5	65968.0	41119.5
Авлага	237171.2	219759.3	-17411.9
Урьдчилгаа			
Бараа материал	156146.8	184692.0	137654.8
Үндсэн хөрөнгө	3247159.6	3434755.6	187596.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3665326.1</b>	<b>3905174.8</b>	<b>239848.7</b>
Өр төлбөр	10201.7	6291.5	-3910.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3655124.5	3898883.3	243758.8

<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	3665326.1	3905174.8	239848.7
---	-----------	-----------	----------

Авлага дансны үлдэгдэл 17411,9 мянган төгрөгөөр буурсан нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт болон олон жил дамжсан сургууль, ЗДТГ-ын авлагыг барагдуулсан байна.

Авлага дансны үлдэгдэлд 2013-2017 онуудад үүссэн, он удаан жил болсон 31,958.2 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага, хувь хүнээс авах авлага 187,801.0 мянган төгрөгийн авлага байна. Үүнээс шинээр үүссэн НДШ, ХАОАТ-ын авлага сургууль, ЗДТГ, ИТХ, Соёлын төв зэрэг байгууллагууд нь нягтлан бодогч нарын тооцоолол буруугаас үүссэн, СХСангийн зээлтэй иргэд шүүхийн шатанд явж байгаа 30397.3 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүйгээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь худалдан авалт нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь албан байгууллагууд үндсэн хөрөнгө нэмж бэлтгэсэн ба сургуулийн 40 жилийн ой тэмдэглэсэн, урсгал засвар хийгдсэн зэргээс шалтгаалжээ. Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 368,367.6 мянган төгрөгийн ЗДТГ, Сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв зэрэг байгууллагуудын хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн /буурсан/ нь өр төлбөр барагдуулах арга хэмжээ авч ажилласнаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 3829.0 мянган төгрөгийн ЖДҮДСангийн зээлийн эргэн төлөлт сум хөгжүүлэх сангийн дансанд нь нийт өр төлбөрийн 60 хувийг эзэлж байна.

Бусад 565.5 мянган төгрөгийн өр ЗДТГ ХАОАТ, НДШ тооцооллын буруугаас шалтгаанаас үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3898883.3 мянган төгрөг болж 243758.8 мянган төгрөгөөр өссөн байна.

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Орон нутгийн татварын орлогыг тайлант онд 59,996.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 73,942.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 123 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мян.төг/

Орлогын нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
<b>НИЙТ ОРЛОГО</b>	59,996,600.0	73,942,711.46	13,946,111.5
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>43,396,600.0</b>	<b>52,891,307.5</b>	9,494,707.5

<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>28,700,000.0</b>	<b>36,784,475.2</b>	8,084,475.2
Үйл ажиллагааны орлого	1,200,000.0	1,099,120.6	(100,879.4)
Хөрөнгийн орлого	9,500,000.0	11,259,270.0	1,759,270.0
Шууд бус орлого	18,000,000.0	24,426,084.6	6,426,084.6
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>1,770,000.0</b>	<b>1,734,000.0</b>	(36,000.0)
Бууны албан татвар	1,770,000.0	1,734,000.0	(36,000.0)
<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>10,376,600.0</b>	<b>12,238,888.3</b>	1,862,288.3
Улсын тэмдэгтийн хураамж	3,063,000.0	4,689,316.0	1,626,316.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,300,000.0	3,744,223.0	(555,777.0)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	3,013,600.0	3,805,349.3	791,749.3
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>2,550,000.0</b>	<b>2,133,944.0</b>	(416,056.0)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,550,000.0	2,133,944.0	(416,056.0)
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>16,600,000.0</b>	<b>21,051,404.0</b>	4,451,404.0
<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>16,600,000.0</b>	<b>21,051,404.0</b>	4,451,404.0
Торгуулийн орлого	12,500,000.0	17,216,667.0	4,716,667.0
Түрээсийн орлого	4,100,000.0	3,834,737.0	(265,263.0)

Шууд бус орлого, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын хураамж, хүү торгуулийн орлого 13,560.8 мянган төгрөгөөр давсан нь төсөвт байгууллагын худалдан авалт нэмэгдсэн хог хаягдлын хураамжийг шинэчлэн тогтоосон, тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж сунгалт хийгдсэн байна.

Үйл ажиллагааны орлого, бууны татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, түрээсийн орлого нь 692.6 мянган төгрөгөөр тасарсан нь ноогдол буруу тооцоолсон, татварын байцаагчгүй байсан зэргээс шалтгаалсан байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 2068037.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2068037.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 61626.6 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1135270.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 846106.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14309.3 мянган төгрөгийг 97546.3 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан зарцуулсан ба орлогын биелэлтийг хангахад тодорхой ажил зохион байгуулж ажилласан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан гаргасан нь төсвийн хэмнэлт гаргах зардлыг эдийн засгийн ангиллын дагуу гаргаж ажилласан.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 49691.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 47245.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Засгийн газрын нөөц сан/Засаг даргын нөөц хөрөнгө/ 20615.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 1141.9 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2056.2 нийт 23813.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс багаж техник хэрэгсэлд 9830.0 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардалд 9711.3 нийт 23645.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 167.9 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 4 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 692.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 692.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 692.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаар санхүүгийн үйл ажиллагааг үр нөлөөтэй зохион байгуулах, төсвийн шууд захирагчийн дотоод хяналт, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

- Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 20747.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 7305.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 3976.3 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 9465.3 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн зэрэг нь санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт сул байгааг харуулж байна.

#### **2.13. Шилэн дансны мэдээлэл**

Баяннуур сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийт 154 мэдээлэхээс 130 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 795.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 795.0 мянган төгрөгийг барагдуулсан, 501.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баяннуур 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### *Менежментийн захидал*

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### *3.1 Орлогын данстай холбоотой асуудал*

#### *3.1.1 Илрүүлэлт:*

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээрээ 13946.1 мянган төгрөгөөр давж биелсэн, орлогыг нэр төрлөөр авч үзвэл шууд бус орлого 6426.1, улсны тэмдэгтийн хураамж 1626.3, хог хаягдлын үйлчилгээний хураамж 791.7, торгуулийн орлого 4716.6 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн бол үйл ажиллагааны орлого 100.9, бууны албан татвар 36.0, түгээмэл тархацтай ашигт

малтмал ашигласны төлбөр 555.8, ан амьтны нөөц ашигласны төлбөр 416.1 мянган төгрөгөөр тус тус тасалсан байна.

### 3.1.2 Эрсдэл:

Төлөвлөөгүй орлого орсноор зориулалт бус зардал гарах, хууль журам зөрчигдөх,

### 3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын өөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, жил бүрийн орлогын биелэлтэнд дүн шинжилгээ хийж орлогыг бүрэн төлөвлөх, тасарсан орлого биелэх боломж байгаа эсэх талаар судалгаа хийж байх.

### 3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй.

## 3.2. Төсвийн шууд захирагчтай холбоотой асуудал

### 3.2.1 Илрүүлэлт:

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангаар нийт 20747.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсний 7305.9 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож, 3976.3 мянган төгрөгт албан шаардлага бичиж, зөрчлийг давтан гаргахгүй байх 9465.3 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

### 3.2.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

### 3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн шууд захирагч, санхүү, бүртгэлийн ажилтны сахилга хариуцлагыг сайжруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

### 3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

## 3.3 Удирдлагатай холбоотой асуудал

### 3.3.1 Илрүүлэлт:

Сумын Засаг дарга нь Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх заалтыг зөрчин цэцэрлэгийн эрхлэгчид Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг дүгнэж үр дүнгийн урамшуулал олгох шийдвэр гаргасан нь Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан аймгийн Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлсэн зөрчил байна.

### 3.3.2 Эрсдэл:

Хууль журам, зөрчигдөх.

### 3.3.3 Өгсөн зөвлөмж:

Төсөв захирагч нар хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төсвийг захиран зарцуулах эрх зүйн актыг гаргаж байх.

### 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Саналгүй

Төсвийн захирагч зөвшөөрсөн Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Д.АНХБАЯР
АУДИТЫН МЕНЕЖЕР	Ж.ЭНХЦООДОЛ
БЭЛТГЭСЭН:	
АХЛАХ АУДИТОР	П.СОДНОМ

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>418,166,528.36</u></b>	<b><u>470,419,288.18</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	24,848,541.06	65,968,035.39
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	24,848,541.06	65,968,035.39
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	24,848,541.06	65,968,035.39
31211	Төрийн сангийн харилцах	24,827,655.90	65,733,303.36
31213	Арилжааны банк дахь харилцах	20,885.16	234,732.03
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	237,171,162.02	219,759,291.09
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	912,069.40
33300	Татаас, санхүүжилтийн авлага	165,918.00	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	237,005,244.02	218,847,221.69
3351	Байгууллагаас авах авлага	32,969,499.02	31,046,200.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	204,035,745.00	187,801,021.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	156,146,825.28	184,691,961.70
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	40,769,608.56	43,163,445.98
35110	Тусгай зориулалттай материал	32,565,246.00	33,095,916.00
35130	Эм боох материал	8,204,362.56	10,067,529.98
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	113,130,216.72	141,528,515.72
35410	Бичиг хэргийн материал	2,482,500.00	3,678,550.00
35420	Аж ахуйн материал	61,378,381.37	87,449,560.37
35430	Сэлбэг хэрэгсэл	2,532,000.00	2,600,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,384,474.90	3,265,674.90
35450	Барилгын засварын материал	33,761,170.00	34,771,170.00
35460	Хүнсний материал	7,440,240.45	9,642,360.45
35470	Бусад хангамжийн материал	151,450.00	121,200.00
35600	Мал амьтад	2,247,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,247,159,605.9</u></b> <b>5</b>	<b><u>3,434,755,559.4</u></b> <b>4</b>

39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,247,159,605.9 5	3,434,755,559.4 4
392	<b>Биет хөрөнгө</b>	3,174,789,334.8 7	3,362,599,559.4 0
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,856,319,416.8 2	3,082,319,416.8 2
39202	Хуримтлагдсан элэгдэл	(177,466,838.27 )	(330,810,400.34 )
39203	Авто-тээврийн хэрэгсэл	302,866,800.00	326,411,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(177,986,986.71 )	(210,598,680.19 )
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	332,302,650.10	390,610,810.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,639,529.21 )	(209,286,699.79 )
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	143,474,546.97	181,033,518.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	(75,928,724.72)	(87,610,172.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	260,721,333.00	342,214,146.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(118,146,370.11 )	(133,201,416.55 )
39217	Ном	11,273,037.00	11,517,237.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	72,370,271.08	72,156,000.04
39301	Програм хангамж	2,555,000.00	2,555,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(940,728.92)	(1,154,999.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	70,756,000.00	70,756,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,665,326,134.3</b> <b>1</b>	<b>3,905,174,847.6</b> <b>2</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>10,201,678.30</b>	<b>6,291,516.80</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	10,201,678.30	6,291,516.80
413	<b>Өглөг</b>	10,201,678.30	6,291,516.80
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,977,438.80	565,516.80
4136	<b>Бусад өглөг</b>	8,224,239.50	5,726,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,224,239.50	5,726,000.00
